

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**



УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг
үнэн, зөв илэрхийлсэн байна.**

Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

2017 оны 04 сар

УВААГ-2017/279-СТА

УВААГ-/2017/279/-СТА

2017 оны 04 дүгээр сар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг Үндэсний аудитын газрын захиалга, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд үндэслэлтэй баталгаагаар хангахад чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

1. Увс аймгийн 2016 оны төсвийн төлөвлөлт
2. Увс аймгийн 2016 оны төсвийн орлогын гүйцэтгэл
3. Увс аймгийн 2016 оны төсвийн зарлагын гүйцэтгэл
4. Увс аймгийн 2016 оны төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Аудитын хамрах хүрээ

Аудитад Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, судалгаа хийх, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг үнэн,
зөв илэрхийлсэн байна.**

**Бүлэг 1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2016 оны орлого, зарлагыг үндэслэлтэй
төлөвлөжээ.**

**1.1. Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсөв Төсвийн тусгай шаардлагуудыг хангаж
зорилтот түвшинд хүрч чадсан байна.**

Аймгийн ИТХ нь Төсвийн тухай хуулийн 64.1.2-д “тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу аймгийн 2016 оны төсвийн орлогыг 61438.4 сая төгрөгөөр зарлагыг 62044.2 сая төгрөгөөр баталжээ.

Татварын орлогын талаар: Аймгийн төсөвт 2016 онд 4978.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөгдснөөс 96.2 хувийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар бүрдүүлж байна.

Татварын бус орлогын талаар: Татварын бус орлогыг 507.9 сая төгрөгөөр баталжээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын талаар: Орон нутгийн хөгжлийн санд Төсвийн тухай хуулийн 59.3 дах заалтанд тусгагдсан итгэлцүүрийг үндэслэн тусгай аргачлалаар тооцож Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 3893.9 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагджээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн орлогын талаар: Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж буй сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёл, эрүүл мэнд, газрын харилцаа, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалал үйлчилгээ, нийтийн биеийн тамирын үйлчилгээнд зориулж 36696.7 сая төгрөгийг баталсан байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг 17958.9 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2015 оны тодотгосон түвшингээс 768.8 сая төгрөгөөр буурсан байна.

Зардлын 33.6 хувийг цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлд, 45.7 хувийг нийгмийн халамжид зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийгмийн халамжийн сангийн талаар: Нийгмийн халамжийн үйлчилгээнд 8092.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

**1.2. Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөөг
үндэслэлтэй төлөвлөсөн байна.**

Увс аймгийн 2016 оны төсвийн орлогыг аймгийн ИТХ-ын 2015 оны 10/07 тоот тогтоолоор 61438.4 сая төгрөгөөр баталжээ.

МУ-ын Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгээр өгсөн зөвлөмжийн дагуу 2016 оны 11/05 тоот тогтоолоор төсвийн орлогыг 61603.4 сая, нийт зарлагын хэмжээг 62980.8 сая, 2016 оны 2/01 тоот тогтоолоор төсвийн орлогыг 61384.3 сая, төсвийн зарлагыг 63274.9 сая төгрөгөөр баталжээ.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

		/сая.төг/	
Төсөв	Анх батлагдсан	Тодотгол 2016.05.20- ны 11/05	Тодотгол 2016.10.26- ны 2/01
Аймгийн төсвийн орлого	61438,4	61603,4	61384,3
1 Урсгал орлого	6517,9	6554,8	6888,6
1.1 Татварын орлого	5812,7	5798,9	5889,1
1.1.1 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-920,0	-933,8	933,8
1.1.2 Өмчийн татвар	398,8	398,8	398,8
1.1.3 Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	225,0	225,0	225,0
1.1.4 Бусад татвар /төлбөр хураамж	847,1	847,1	852,1
1.2 Татварын бус орлого	705,2	755,9	999,5
2 Хөрөнгийн орлого	147,0	197,0	197,0
2.1 Орон нутгийн өмчийг худалдан борлуулсны орлого	147,0	197,0	197,0
3 Тусламжийн орлого	54773,5	54851,6	54298,7
3.1 Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	11597,0	11597,0	11444,8
3.2 Орон нутгийн хөнжлийн сангийн орлогын шилжүүлэг	3893,9	3893,9	3893,9
3.3 Тусгай зориулалтын шилжүүлэг	37629,2	37629,2	38081,0
3.4 ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	67,6	145,7	145,7
3.5 Бусад тусламж	1585,8	1585,8	1585,8

2016 оны төсвийн 2 удаагийн тодотголоор орон нутгийн төсвийн орлогыг анх батлагдсанаас 54.1 сая төгрөгөөр бууруулан 61384.3 сая төгрөгөөр баталсан байна.

1.3 Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал өнгөрсөн оноос буурсан байна.

Увс аймгийн 2016 оны төсвийн урсгал тэнцэл 49949.0 сая, нийт тэнцэл 1890.6 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр урсгал тэнцэл 49365.2 сая, нийт тэнцэл 106.8 сая төгрөгийн алдагдалтай гарсан байна.

**Бүлэг 2. Увс аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн орлогыг төлөвлөсөн
хэмжээнээс давуулан биелүүлжээ.**

2.1 Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээг бүрэн авч ажилласан байна.

Увс аймгийн 2016 оны нийт орлогыг 61384.3 сая төгрөг, суурь зарлагыг 63274.9 сая төгрөгөөр тооцож, улсын төсвөөс 1890.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөсөн байна.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны төсвийн орлогыг өмнөх онтой харьцуулсан судалгаа
/сая.төг/

Орлогын нэр	2015 он	2016 он	Зөрүү
Урсгал орлогын дүн	6494,9	7415,6	920,7
Татварын орлого	5979,8	6786,1	806,3
Татварын бус орлого	515,1	629,5	114,4
Тусламжийн орлого	53537,7	54133,3	595,6
Нийт орлого ба тусламжийн дүн	60032,6	61548,9	1516,3

2016 оны Орон нутгийн орлогыг өмнөх онтой харьцуулбал 2.5 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд орон нутгийн урсгал орлогын 91.5 хувийг татварын орлого, 8.5 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

2.2 Тайлант онд орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

2016 оны төсвийн нийт орлого ба тусламжийн орлогын дүн гүйцэтгэлээр 61548.9 сая төгрөгт хүрч, төлөвлөснөөс 164.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тухайлбал: Татварын орлогоос цалингийн ашиг 238.0 сая, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 60.0 сая төгрөгөөр давж, бусад нэр төрлийн татварын төлөвлөгөө тасарч нийт дүнгээрээ 80.0 сая төгрөгөөр давсан байна.

2.3. Орлогын бүх гүйлгээ тухайн Төсөв захирагчийн төрийн сангаар дамжин хийгдсэн байна.

Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу Төсвийн байгууллагуудын болон төсөл сангийн орлого, зарлагын гүйлгээ Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжин хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийгдсэн байна.

Сангийн сайдын 2011 оны 131/25/1289 тоот гэрээний дагуу арилжааны банкуудад татварын нэр төрлөөр нь “тэг” үлдэгдэлтэй данс нээж тухай бүр нь төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлж байна.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Бүлэг 3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

3.1 Увс аймгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс хэмнэгдсэн байна.

Увс аймгийн Нэгдсэн төсвийн зарлагыг 2016 онд 62044.2 сая төгрөгөөр төсөвлөн баталж 2 удаагийн тодотголоор 1230.7 сая төгрөг нэмж 63274.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэл болон төлөвлөгөөтэй
харьцуулсан судалгаа

/сая. төг/

Зардлын нэр	2015 он	2016 он		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	60519,8	63274,9	61655,8	-1619,1
Урсгал зардал	53893,4	56823,6	56767,0	-56,6
Хөрөнгийн зардал	5439,6	4614,2	4317,2	-297,0
Татаас		14,0	14,0	-
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1186,8	1823,1	557,7	-1265,4

Засгийн газрын 2014 оны 147 тоот тогтоолоор баталсан “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” чиглэлийн дагуу аймгийн ИТХурал Орон нутгийн төсөв батлахдаа “бүх шатны Засаг даргын орлогч, төсөвт байгууллагын дэд дарга, даргын туслах, төсвөөс цалинждаг зөвлөх зэрэг орон тоог цөөлөх, цомхотгох, **гадаад албан томилолтын зардлыг бууруулах**, орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд нийцүүлж спорт заал, соёлын төв зэрэг **төсөвт байгууллагын барилга байгууламжийг төвлөрсөн дулааны системд холбох**, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан халаалт зэрэг бусад үр ашигтай арга, технологи нэвтрүүлэх замаар түлш, халаалтын зардал хэмнэх, цаашид ийм төрлийн зардлыг тогтмол түвшингээр төсөвлөх, улмаар үе шаттай бууруулах” зэрэг хүчин зүйлсийг харгалзан төсвийн зарлагыг тодорхой хэмжээгээр бууруулсан байна.

2016 оны нийт зардал төлөвлөснөөс 1619.1 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь тайлант онд төсвийн байгууллагууд жирэмсэний амралттай хүний оронд өөр хүн ажиллуулаагүй, зарим сумд нүүдлийн цэцэрлэг ажиллуулаагүйгээс цалингийн зардал, ханиад томууны дэгдэлт их байсантай холбогдуулан хүүхдийн амралт тавьснаас хоолны зардал, зарим төсөвт байгууллага, сумд нэгдсэн халаалтад холбогдсноос гэрээтийн зардал, зарим байгууллагын тэтгэврийн насны хүмүүс тэтгэвэрт гараагүйгээс нэг удаагийн тэтгэмжийн зардал, хуваарьт сургалт хийгдээгүйгээс эрүүл мэндийн хөтөлбөрийн зардал, намар оройтож засварын ажил хийгдсэнээс зарим байгууллага түр хугацаанд ажиллаагүйгээс тогтмол зардлууд тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн хэмжээнд төсөвт байгууллагууд 2016 онд гадаад томилолтын зардалд 4.6 сая төгрөг зарцуулж өмнөх оноос 36.8 хувиар буурсан байна.



Төсвийн нийт зардлын 61.5 хувийг тусгай шилжүүлгийн зардал, 33.2 хувийг орон нутаг, 5.3 хувийг төсөл сангийн зардал эзэлж байна.

3.2. Улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын талаар:

Монгол улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 14 төсөл арга хэмжээний 1102.2 сая төгрөгийн эрх Төсвийн ерөнхийлөн захирагчид шилжин ирсэн байна.

Увс аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний эх үүсвэр дараах байдалтай батлагдаж санхүүжилт олгогдсон байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт

Д/Д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	/сая. төгрөг/	
		2016 онд санхүүжих дүн	2016 онд олгосон санхүүжилт
1	Сургуулийн барилгын засвар /Увс, Завхан сум/	93.2	88.12
2	Увс аймгийн Цогцолбор 1-р сургуулийн сантехникийн засварын ажил	150.0	142.18
3	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Өндөрхангай сум/	50.0	46.12
4	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Зүүнхангай сум/	50.0	47.2
5	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Тэс сум/	129.00	121.1
6	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Бөхмөрөн сум/	50.0	44.78
7	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Хяргас сум/	50.0	
8	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Ховд сум/	50.0	45.74
9	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Малчин сум/	50.0	46.65
10	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Завхан сум/	50.0	46.5
11	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Баруунтуруун сум/	50.00	47.47
12	Сумын төвийн тохижилт /Увс аймгийн Цагаанхайрхан сум/	50.00	46.91
13	Тоног төхөөрөмж авах./Увс аймаг/	200.0	198.0
14	Сургуулийн барилгын засвар /Увс, Өлгий сум/	80,0	
	Дүн	1,102.2	920.8

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 тоот тогтоолоор Увс аймагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээг тодотгон баталсан байна. Орон нутгийн төсөв, байгаль хамгаалах сан, автозамын сангийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжих төсөл арга хэмжээний эх үүсвэрийг дараах байдлаар баталж санхүүжилт олгосон байна.

		/сая төгрөгөөр/	
Д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	2016 онд санхүүжих дүн	2016 онд олгосон санхүүжилт
	1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар :		
1	Зүүнхангай суманд орон сууц.	60.0	60.0
2	Нэгдсэн эмнэлэгт гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж.	5.0	5.0
3	Өндөрхангай суманд зайн оношлогооны багаж тоног, төхөөрөмж	14.0	14.0
4	Нэгдсэн эмнэлэгт эх барих цомог /нэг удаагийн/	18.9	18.9
5	Цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны засварын дутуу.	35.0	35.0
6	Ойрад түмний язгуур урлагийн олон улсын наадам	10.0	10.0
7	Цогцолбор 2-р сургуулийн дотуур байрны засварын санхүүжилтийн дутуу.	200.0	200.0
8	Орон сууц худалдан авах /орон нутгийн өмч 101/	70.0	70.0
9	Ахлах 4-р сургуулийн гадна авто зогсоолын өргөтгөл Улаангом 288м²	19.0	18.7
10	1-48 айлын орон сууцны гадна авто зогсоолын өргөтгөл, Улаангом	16.0	15.7
11	Улаангом сумын 6-р багт Улиасны хэв чиглэлийн замд автобусны зогсоол хийх, 350 м шороон зам барих	16.0	15.7
12	Икел хөгжмийн талбайн тохижилт, Улаангом 3-р баг	15.0	14.8
13	30 айлын орон сууцны хэрэглээний халуун усны шугам холбох /Улаангом 3-р баг/	11.0	11.0
14	Хатан түрүү ОНӨААТҮГ-ын өр барагдуулах	50.0	49.8
15	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварт дэмжлэг /ходоодны дуран/	10.0	10.0
	2. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар :		
1	Баруунтуруун сумын Шар ширэнгэд уулын ойжуулалт хийх	21.0	20.1
2	Увс аймгийн нутаг дэвсгэрт нарийвчилсан агнуур зохион байгуулалтын төлөвлөгөө хийх.	20.0	19.9
3	Увс аймгийн Улаангом сумын зам дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулах	61.5	61.0
	3. Автозамын сангийн хөрөнгө оруулалтаар :		
1	Наранбулаг сумын үерийн хамгаалалтын шуудуу татах	10.0	9.7
2	Увс аймгийн Зүүнговь сумын Гурамсны гүүр чиглэлийн замыг засаж сайжруулах.	50.0	38.7
3	Увс аймгийн Улаангом сумын Чандманий 1-р буудлаас 2-р буудал хүртэлх замыг засаж сэлбэх.	40.0	34.5

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

4	Улаангом сумын үерийн далан засварлах.	10.0	10.0
5	Увс аймгийн Улаангом сумын 4-р сургуулийн гадна авто зогсоол хийх	20.0	17.5
6	1-48 айлын гадна зогсоол хийх .	15.0	12.9
7	Гашууны гол чиглэлийн замыг засаж сайжруулах	32.5	26.5
8	8-р багт Хөндлөнгийн гарам барих	25.0	24.1
	Нийт дүн	854.9	823.3

Бүлэг 4. Халамжийн сангийн 2016 оны төсөв

Халамжийн сангаас 8092.6 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 8070.1 сая төгрөг зарцуулж 22.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Зардлын задаргааг харуулбал:

/мян.төг/

Д/д	Төрөл	2016 оны батлагдсан	2016 оны тодотгосон төсөв		2016 оны гүйцэтгэл	Зөрүү
			2016.05 сар	2016 оны 10 сар		
1	Халамжийн тэтгэвэр	3216830.0	2951830.0	2917016.2	2747860.7	-169155.5
2	Нөхцөлт мөнгөн тэтг	1282728.0	1282728.0	1247728.0	1266807.9	19079.9
3	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	865416.0	865416.0	865416.0	925502.6	60086.6
4	Жирэмсэн хөхүүл эхч	1104000.0	1104000.0	1038000.0	1020265.9	-17734.1
5	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	40000.0	60000.0	60000.0	60000.0	0.0
6	Ахмад настны хөнгөл	729730.0	729730.0	699730.0	677646.4	-22083.6
7	Хөгжлийн бэрхшээлт	398835.0	398835.0	398835.0	506627.7	107792.7
8	Хоол тэжээлийн хөнг	575546.5	820546.5	820546.5	820535.0	-11.5
10	ТНӨГАҮ	36000.0	36000.0	36000.0	41102.0	5102.0
11	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9300.0	9300.0	9300.0	3776.2	-5523.8
	Дүн	8258385.5	8258385.5	8092571.7	8070124.4	-22447.3

Бүлэг 5. Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсөв

5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 15120.3 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 15519.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн ба нийт дүнгээрээ 399.3 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Орлогын төрлөөр

/мян.төг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хувиар/
Тэтгэвэрийн даатгал	8620685,4	9106312,6	105,6
Тэтгэмжийн даатгал	975915,8	1023139,6	104,8
ҮОМШӨ-ний даатгал	706613,0	775543,0	109,8
Ажилгүйдлийн даатгал	244395,0	227704,0	93,2
Эрүүл мэндийн даатгал	4572715,0	4386956,8	95,9

Тайлант хугацаанд шинээр 73 аж ахуйн нэгж байгууллага нийгмийн даатгалын сангийн баазад нэмэгдэж бүртгүүлснээр нийгмийн даатгалын орлого нэмэгдсэн, мөн Засгийн газрын шийдвэрээр тэтгэмжийн сангийн даатгалаас ҮОМШӨ-ний даатгалд 0.2 хувийн орлогыг төвлөрүүлснээс орлого давсан байна. Даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлого 185.7 сая төгрөгөөр тасарсан нь малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй иргэдийн ЭМД-д хамрагдалт хангалтгүй байсантай холбоотой байна.

5.2 Нийгмийн даатгалын сангийн зардал

Тайлант онд тэтгэврийн нэр төрөл бүрээр 40339.7 сая төгрөгийн зардал төлөвлөн гүйцэтгэлээр 39670.9 сая төгрөг зарцуулж, 668.8 сая төгрөгийн үлдэгдлийг нийгмийн даатгалын ерөнхий санд төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл:

/мян.төг/

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /хувиар/
Тэтгэвэрийн даатгал	34349099,6	33777470,5	98,3
Тэтгэмжийн даатгал	1806891,0	1661958,0	92,0
ҮОМШӨ-ний даатгал	173226,0	87253,0	50,4
Ажилгүйдлийн даатгал	226656,0	388348,0	171,3
Эрүүл мэндийн даатгал	3783792,0	3755879,0	99,3

Тайлант хугацаанд ажилгүйдлийн даатгалын зардал төлөвлөснөөс 171.3 хувиар хэтэрсэн нь сонгуулийн жилд улс төрийн болон бусад ажилтнууд ажилгүй болсонтой холбоотой байна.

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Бүлэг 6. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

2016 онд нэмэлт төсвөөр 2546.0 сая төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.
/сая.төг/

Салбарын нэр	Өмнөх гүйцэтгэл	оны	2016 он	
			Санхүүжилт	Зарцуулалт
БСШУСайд	304,3		359.9	359.9
ЭМСайд	145,4		89.2	89.2
БХБСайд	63,2		22.9	22.9
НХХСайд	46,2		169.4	169.4
Засаг дарга	2229,5		1904.6	1904.6

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл**

Дүгнэлт

Энэхүү гүйцэтгэлийн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2016 оны орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөжээ.
2. Татварын зарим нэр төрлийн орлогыг давуулан биелүүлжээ.

Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Д.Батсайханд:

1. Татварын зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байх.

Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

213400, Улаангом, Увс аймаг
Утас/Факс: 7045-2012

2017. 04.20 № 5/492

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн
төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах
болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЭРДЭНЭСҮРЭН



12 644

My: doc zisag-A5

**Увс аймгийн 2016 оны нэгдсэн
төсвийн гүйцэтгэл****Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар**

Увс аймгийн 2016 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсээс ирүүлсэн 2017 оны 04 сарын 20-ны өдрийн 5/482 албан тоотыг үндэслэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ТАЙЛАН БИЧСЭН: АУДИТОР

М.БАТ-АМГАЛАН